



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/55

Хэрлэн сум

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сарын шинийн баярыг тохиолдуулан 90 ба түүнээс дээш настай ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 12,160,200 (арван хоёр сая нэг зуун жаран мянга хоёр зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 05-ны
0/55 дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Хүндэтгэл үзүүлж гардуулах бэлэг	114	82,300	9,382,200
2	Бэлэгний хайрцаг	300	9,260	2,778,000
		Нийт		12,160,200